

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

Бусдад гэрэл байх нь

Далын ахлагч Суй Хонг Пон

Азийн Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх



Далын ахлагч

Суй Хонг Пон

“Гэрэл” гэдэг үг нь сайн мэдээний сургаалд хамгийн нийтлэг ашиглагддаг үг хэллэгүүдийн нэг юм. Төлөөлөгч Иохан өөрийнхөө үүргийг “Ертөнцөд ирэх хүн бүрийг гэгээрүүлдэг жинхэнэ гэрэл болох”¹ тэрхүү “гэрлийн тухай гэрчлэх”² хэмээн тунхагласан байдаг.

Бидний Их Эзэн Есүс Христ “Би бол ертөнцийн гэрэл мөн”³ хэмээн тунхагласан байдаг. Христийг төрөх үед Түүнийг Иерусалимаас хайж олоход мэргэдийг удирдах шинэ од гарч ирнэ⁴ хэмээн ийнхүү тунхаглан бошиглосон. Лемең үндэстэн бошиглогч Самуел ч мөн адил Түүнийг дэлхийд ирэх үед “тэнгэрт агуу гэрлүүд байх болно, үүний хэрээр түүнийг ирэхийн өмнөх шөнө харанхуй болохгүй, үүний хэрээр энэ нь хүмүүнд өдөр мэт үзэгдэх болно. Тиймийн тул, нэг өдөр мөн шөнө мөн өдөр, шөнөгүй нэгэн өдөр лугаа адил байх болно; мөн энэ нь та нарт тэмдэг байх болно; учир нь та нар нар ургахыг мөн түүнчлэн шингэхийг нь мэдэх болно; тиймийн тул тэд хоёр өдөр мөн нэг шөнө болохыг гарцаагүй мэдэх болно; гэсэн хэдий ч шөнө нь харанхуйлахгүй; мөн энэ нь түүний төрөхийн өмнөх шөнө байх болно. Мөн болгоогтун, та нарын хэзээ ч тийм нэгнийг болгоогүй тэрхүү нэгэн шинэ од гарах болно; мөн энэ нь түүнчлэн та нарт тэмдэг байх болно”⁵ хэмээжээ. Гэхдээ, “Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно”⁶ гэсэн нь дэлхийн гэрэл байх тухай өгүүлсэн хамгийн чухал захиас юм.

Дэлхий дээрх тохинууллынхаа үеэр Их Эзэн Есүс Христ бидэнд хэрхэн гэрэл байхын агуу үлгэр жишээг үзүүлсэн бөгөөд үүнийхээ хариуд биднээс мөн адил дэлхийн гэрэл байхыг хүссэн юм. Тэр биднээс “Хүмүүс та нарын сайн үйлсийг хараад, тэнгэр дэх Эцэгийг тань алдаршуулахын тулд та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг”⁷ хэмээн хүссэн билээ.

Түүнчлэн “гэрэл” гэсэн үгийг олон сударт бошиглогч, төлөөлөгчдийн үгэнд сайн мэдээ, мэдлэг болон Ариун Сүнсний удирдамж зэргийн талаар дурдахад эш татсан байдаг. Бид гэрлийг жишээ болгон, тэр тусмаа гэрлийг харанхуйтай харьцуулан ашиглахад эдгээр сургаалын утгыг илүү амархан ойлгодог билээ.

Гэрэл нь удирдамж, чиглүүлэл, найдвар, аюулгүй байдлыг болон ойлголтыг төлөөлдөг хэмээн бид ойлгодог. Харанхуй үед аюул заналхийлэл, айдас түгшүүр, сэтгэл зовнид, будлиан төөрөгдлийн сэтгэгдлээс гарахын тулд бидний үргэлж эрэлхийлэн хайдаг эх сурвалж бол гэрэл билээ. Бид бүгдээрээ хүчтэй гэрлийг хүлээн авахыг эсвэл бидэн дээр гэрэл тусах үед уг гэрлийг хүчтэй ойлгон тусгахыг хүсдэг. Ийм болохын тулд бид гэрлийг авч явах эсвэл гэрлийг ойлгон тусгах зохистой байхуйг цэвэршигдэн, ариун болсон байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл бидний гэрлийн эх сурвалж болох сүнслэг хүч чадлыг өөртөө хөгжүүлэх хэрэгтэй. Эдгээр сүнслэг хүч чадал нь биднийг итгэлээрээ зарлиг,

гэрээнүүдээ дагаж, ариун журамтай амьдрах үед ирдэг. Бид сүйт залуутай уулзахаар бэлдэхдээ савандаа хангалттай тос авч явсан ухаалаг онгон охидын адил болох хэрэгтэй. Бид гэрлийг ойлгон тусгаж чадахгүй халтар толь болж болохгүй.

Заримдаа бид бусдын гэрэлд тулгуурлаж болох ч бид өөрсдийнхөө гэрлийн эх сурвалж болох хэрэгтэй. Их Эзэн бидэнд “Надад ойр байгтун, мөн би та нарт ойр байх болно; намайг хичээнгүйлэн эрэлхийлэгтүн, мөн та нар намайг олох болно; асуу тэгвэл та нар хүлээн авах болно; тогш, тэгвэл энэ нь та нарт нээгдэх болно”⁸ хэмээн заасан. Бид Их Эзэний амлалт бидэнд биелэгдэж, өөрийн гэсэн гэрлийн эх сурвалжийг хөгжүүлэх тусламжийг хүлээн авахын тулд үйлдэх хэрэгтэй.

Хилэнцэт нэгэн биднийг төөрөгдүүлэн, улмаар урхиндаа оруулахаар тавьсан уруу таталтаар хүрээлэгдсэн энэ үед дэлхийн гэрэл байх тийм ч амар хялбар байхгүй байж магадгүй. Нэгэнт уруу татагдсан л бол зарим үед бид эдгээрээс бараг мултран гарч чадахааргүй болж, улмаар бидний гэрэл бөхдөг. Аюулгүй байж, гэрлээ хадгалан үлдэхийн тулд бид эдгээр уруу таталт нь юу болохыг олж тогтоон, тэдгээрээс зайлсхийх шийдвэртэй гуйвшгүй байх ёстой.

Өнөө үед, урьд өмнө нь зөв шударга бус хэмээн тооцогддог байсан зүйлс одоо хүлээн зөвшөөрөгдсөн хэмээн итгүүлэх гэсэн хүмүүсийг хаанаас ч олж харах

боломжтой. Бид “Сайныг муу гэх, мууг сайн гэх тэдэнд, мөн гэрлийг харанхуйгаар орлуулах, гэх тэдэнд, гашуунаар амттайг, мөн амттайгаар гашууныг орлуулах тэдэнд халаг!”⁹ гэсэн судрыг санаж байгаасай хэмээн би найдаж байна. Бид уруу татагдах үедээ “Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл юм. Бурхан итгэмжит билээ. Тэр та нарыг хэрээс чинь хэтэрсэн хүчээр соригдохыг зөвшөөрдөггүй, харин *сорилтыг* тэсвэрлэж чадахын тулд сорилттой хамт мөн гарах замыг ч өгдөг юм.”¹⁰ хэмээн тунхагласан төлөөлөгч Паулын ухаалаг сургаалыг санаж байх хэрэгтэй.

Ахлагч Нийл Л.Андэрсэн 2015 оны 8-р сарын 18-нд Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр “Зөв шударга хүмүүст нөхөн олгогдох сүнслэг хүч” гэсэн хэлсэн үгэндээ: “Дэлхий даяар хилэнц өсөн нэмэгдэх үед зөв шударга хүмүүст сүнслэг хүч нөхөн олгогддог. Дэлхий сүнслэг байдлынхаа зангуунаас хөдлөхөд Их Эзэн Өөрийг нь эрэлхийлж байгаа хүмүүсийн аялж буй сүнслэг чиглэлд нь илүү их нотолгоо, баталгаа, итгэл үнэмшлийг өгч тэдэнд замыг бэлтгэдэг юм. Харин Ариун Сүнсний бэлэг нь бүрхэх харанхуйд илүү тод гэрэл болон хувирдаг билээ”¹¹ хэмээн заасан. Ариун Сүнсний хамт байх боломжийг олгодог бидний зохистой байдал нь бусдын хувьд гэрэл байхад бидний хүчирхэг эх сурвалж болох юм.

Христийнхтэй адил зан чанартай байх нь бидэнд амьдрал дахь гэрлээ хүчтэй тусгах боломжийг олгох болно. Бидний Их Эзэн Есүс Христ, “Намайг дага” хэмээх Өөрийн урилыг бид бүхэнд өгсөн. Төлөөлөгч Паулын Тимотод хүргүүлсэн захидал дээр: “чи итгэгч хүмүүст үг, зан байдал, хайр, итгэл хийгээд цэвэр

ариун байдлаараа үлгэр дуурайл бол”¹² хэмээн тодорхойлсны дагуу Бидний шавь байх байдал нь бидний хэн болохыг бусдад тусган харуулж байх ёстой. Бид эдгээр сургаалын дагуу үйлдэх хэрэгтэй.

Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулганы санваарын хуралдаан дээр: “Сүм бол автомашины үзэсгэлэнгийн танхим биш энэ нь бидний сүнслэг байдал, мэдлэг чадвар эсвэл эд баялгаа бусдад гайхуулдаг газар биш. Энэ бол харин эвдрэл гэмтэл болон үйлчилгээ хийлгэхээр ирдэг машины засварын төвтэй илүү адил юм”¹³ гэж хэлсэн. Харин ерөнхийлөгч Томас С.Монсон 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгэндээ бидэнд хэрхэн хэл, яриа, энэрэл, сүнс, итгэл, цэвэр ариун байдлаараа бусдад үлгэр жишээ болж чадах талаар тайлбарлан, хүчирхэг сургаалыг заасан билээ.¹⁴ Бид хэрхэн үлгэр жишээ, гэрэл болж болох талаар суралцан, энэ талаар санаж байхын тулд энэхүү бошиглолын захиасыг ахин дахин уншихыг би та бүхэнд уриалах гэсэн юм.

ГЭГЭЭНТНҮҮДИЙН ГЭРЧЛЭЛ

Мормоны Ном бол Бурханаас бидэнд илгээсэн бэлэг юм

Улаанбаатар баруун гадасны ерөнхийлөгч О.Одгэрэл

Бүхий л түүхэн хөгжлийн явцад Бүхн төрөлхтөнд Бурханы хүслийг мэдэхэд туслах арга хэрэгсэл болон зөвлөгчидтэй байх шаардлага гарсаар иржээ. Библийн сударт эртний бошиглогч Амос заахдаа: “Үнэхээр Эзэн Бурхан зарц нар,

Бүгдээрээ гэрэл болж мөн гэрлийн хүчтэй тусгал болохын тулд цэвэр, ариун байхыг хичээцгээе. Их Эзэн Есүс Христ бол бидний Аврагч мөн Тэнгэрлэг Эцэгийн өмнө зогсох бидний өмгөөлөгч болохыг би мэднэ. Тэр бидний үлгэр жишээ, хүч чадал билээ. Бид бүгдээрээ дэлхийд гэрэлтэх гэрэл болохын тулд Түүнийг хичээнгүйлэн дагах болтугай. Есүс Христийн нэрээр, амен. ■

ЭШЛЭЛ

1. ИСО Иохан 1:9.
2. Иохан 1:7-г үзнэ үү.
3. Иохан 8:12-ыг үзнэ үү.
4. Матай 2:2-ыг үзнэ үү.
5. Хиаламан 14:3-5-ыг үзнэ үү.
6. Иохан 8:12-ыг үзнэ үү.
7. Матай 5:16.
8. Сургаал ба Гэрээ 88:63.
9. 2 Нифай 15:20-ийг үзнэ үү.
10. 1 Коринт 10:13.
11. www.byutv.org/watch/9142b9fc-4520-446e-8992-608d2c2b1ab3/byu-devotional-address-elder-neil-l-andersen-81815-education-week-холобоосыг үзнэ үү.
12. Тимот 4:12-ыг үзнэ үү.
13. Дийтр Ф. Угдорф, “Чин үнэнч байх нь,” *Ensign*, 2015 оны 5-р сар, 83 эсвэл 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 66.
14. Томас С.Монсон, “Үлгэр жишээ мөн Гэрэл байгтун,” *Ensign*, 2015 оны 11-р сар, 87 эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 75-ыг үзнэ үү.



**Улаанбаатар
баруун гадасны
ерөнхийлөгч
О.Одгэрэл**

усаар цангах бус, харин Эзэний үгийг сонсохын төлөөх өлсгөлөн байх юм” (Амос 8:11) гэжээ.

Харамсалтай нь Библийн судрын анхны хувилбар нь хадгалагдан үлдээгүй бөгөөд олон орчуулгын явцад эртний еврей, грек хэлнээс латин, герман зэрэг хэл рүү хөрвүүлэхэд уг судруудад тодорхой хэмжээний өөрчлөлт орсон нь ойлгомжтой юм. Энэ талаар Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Итгэлийн тунхгийн 8-д “Библи зөв орчуулагдсан байхын хэрээр Бурханы үг мөн гэдэгт бид итгэдэг; тэрчлэн Мормоны Ном бол Бурханы үг мөн гэдэгт бид итгэдэг” хэмээн өгүүлдэг. Ийнхүү Мормоны Номыг тэнгэрээс илгээж, түүгээр Бурхан Сайн мэдээний бүрэн байдлыг бидэнд өгсөн юм. Езекиелийн номонд “Эзэний үг надад дахин ирж, Хүний хүү чи нэг савааг өөртөө авч, дээр нь “Иуда болон түүний хамтрагчид болох Израилийн хөвгүүдийн төлөө” хэмээн бич. Тэгээд өөр нэг савааг авч, дээр нь “Ефраимын саваа болох Иосеф ба түүний хамтрагчид болох Израилийн хамаг гэрийн төлөө” хэмээн бич. Тэгээд тэдгээрийг өөртөө, нэгийг нь нөгөөд, нэг саваа болгож, чиний гарт тэдгээрийг нэг болохоор нийлүүл” (Езекиел 37:15-17) гэжээ.

Мормоны Номонд бошиглогч Лихай гэрчлэхдээ: “Мөн тэрчлэн Иосеф бошиглож хэлсэн нь: Болгоогтун, уг үзмэрчийг Их Эзэн адислах болно; мөн түүнийг устгахыг эрэлхийлэх тэд устгагдах болно;

учир нь хэвлийн минь үрсийн талаар, Их Эзэнээс миний олсон, энэ амлалт гүйцэлдэх болно. Болгоогтун, энэ амлалтын биелэлтийн талаар би огт эргэлзэхгүй байна; Мөн түүний нэр минийхээр нэрлэгдэх болно; мөн энэ нь түүний эцгийн нэр байх болно. Мөн тэрээр надтай адил байх болно; уг зүйлийн учир түүний гараар Их Эзэн авчруулах, Их Эзэний хүчээр миний хүмүүсийг авралд авчрах болно” гэсэн байдаг (2 Нифай 3:14-15). Мөн ерөнхийлөгч Жэймс Э.Фауст заахдаа: “Иосеф Смит, Мормоны Ном хоёр нь хожмын үед гүйцэлдүүлж буй Их Эзэн Есүс Христийн ажлын гол цөм нь юм” (“Иосеф Смит болон Мормоны Ном”, *Ensign*, 1996) гэжээ.

Хожмын энэхүү өдрүүдэд бошиглогчид болон илчлэгчдийн амнаас гарах Мормоны Номын талаарх гэрчлэлийг сонсоно гэдэг нь гайхалтай адислал юм. Бидний эргэн тойронд байгаа ах эгч нарын амьдралыг Мормоны Ном хэрхэн өөрчилсөн талаарх гэрчлэлийг сонсох

нь ч бас агуу адислал болдог. Тэр дундаа бяцхан хүүхдүүдийн маань Мормоны Номын талаар хуваалцах тэрхүү гэрчлэл нь мөн л орчин цагийн гайхамшгуудын нэг юм.

Зарим хүн Мормоны Номын талаар гэрчлэл хүлээн аваагүй гэж ярихыг бид нэг бус удаа сонсдог. Хүн бүрд энэхүү гэрчлэл өөрийн цаг хугацаанд ирдэг. Заримдаа олон жил шаардагдаж болох юм. Гэсэн хэдий ч залбиралтайгаар Мормоны Номыг судалж байгаа хүн бүрд энэхүү гэрчлэл эрт орой хэзээ нэгэн цагт заавал ирэх болно.

Сүмд нэгдээд 20 гаруй жил болж байгаа миний хувьд анх Мормоны Номын тухай гэрчлэл сэнхрэл, баяр баяслаар ирж байсныг тодхон санаж байна. Одоо ч гэсэн уг номоос унших бүрд энэхүү гэрчлэл улам бүр батжиж байгааг мэдэрсээр байдаг бөгөөд энэ нь биднийг Их Эзэн Есүс Христэд ойртуулдаг юм. “Мөн үүнийг итгэлд хүлээн авах мөн зөв шударгаар ажиллах тэд мөнх амьдралын титмийг хүлээн авах болно” (С ба Г 20:14). ■

Мормоны Ном надад гайхамшгийг харуулсан

Энхтайван тойргийн гишүүн Т.Билгүүнзаяа

Өнгөрсөн оны дөрөвдүгээр сараас эхэлсэн “Монгол орныг Мормоны Номоор үерлүүлэх нь” зургаан сарын аян миний амьдралыг өөрчилсөн юм. Би энэхүү аянд оролцсоноор анх удаа Мормоны Номыг бүрэн уншиж дуусгасан. Аливаа зүйлийг тодорхой зорилготой хийвэл гүйцэлддэг гэдгийг ойлголоо. Мөн би гэр бүлээрээ Сүмийн гишүүн болохыг маш их хүсч байсан

учраас Мормоны Номыг уншиж эхлэхдээ Бурхантай гэрээ хийсэн юм. Уг гэрээ нь би Мормоны Номыг өдөр бүр чин сэтгэлээсээ уншиж, харин Тэнгэрлэг Эцэг аавыг маань Сүмийн гишүүн болгож өгөх миний хүслийг биелүүлэх тийм

Т.Билгүүнзаяа



гэрээ байв. хаа дараа би Бурханы гайхамшигийг олж харлаа. Аав маань Сүмийн гишүүн болсон юм. Тэр санваар хүртэж, ариун ёслол адисалж, дуудлагат ажил


хүлээн авсан бөгөөд одоо өөрийн бүх чадлаар Бурхандаа үйлчлээд явж байна. Мормоны Ном бүрэн дүүрэн үнэнийг агуулдаг бөгөөд үүнд өчүүхэн ч эргэлзэх хэрэггүй

юм. Надад сургаалын талаар эргэлзэх зүйл огт үгүй болсон. Мормоны Ном үнэхээр үнэн бөгөөд үүнд агуу хүч байдгийг гэрчилж байна. ■

ИНСТИТУТ, СЕМИНАР ГИШҮҮДИЙН АМЬДРАЛД

Хан-Уул тойргийн семинарын багш

Ч.Баасансүрэнгийн гэрчлэл



Ч.Баасансүрэн

Гадасны ерөнхийлөгч надаас “Та өглөөний семинарын багш болох уу?” гэж асуухад семинарын суралцагч байсан дөрвөн жилийн дурсамж минь нүдэнд үзэгдэх шиг болсон. Семинарт сурч байхад минь сүнслэг хичээ-

лүүд заадаг байсан багш нар, үүрийн таван цагт босч биднийг хүргэж өгдөг байсан сайн дурын жолооч

ах нар, халуун аарц, хярам барин ирдэг байсан Халамжийн нийгэмлэгийн эгч нарын агуу золиослолыг харан гайхдаг байснаа эргэн саналаа. Ийнхүү уг урилгыг хүлээн авч, үйлчлэл золиослолын агуу жишээ болсон эдгээр ах эгч нарын эгнээнд зориг муутайхан нэгдсэн минь саяхан мэт санагдана. Суралцагчид маань миний асуултад гэнэн цайлган, хайр хүрэм, заримдаа бүр бахадмаар хариултуудыг өгч, сурах хүсэл эрмэлзэл дүүрэн буйгаа илтгэх мэт багшаа, багшаа хэмээн дуудаж, мэдэхгүй зүйлсээ ам уралдан асуух үед надад маш их урам зориг төрж, тэдний ирээдүй итгэлийнх нь адил гэгээтэй байгааг хардаг. Цаг хугацаа өнгөрөх тусам бидний гэрчлэл

хамтдаа өсөж байгааг харах нь багш хүний жинхэнэ аз жаргал юм билээ. Энэхүү гайхалтай дуудлагыг хийснээр надад ирсэн олон адислалд би талархдаг. Суралцагчдаа илүү сайн хичээл заахын тулд англи хэл дээрх багшийн гарын авлагаас судлах шаардлагатай байсан бөгөөд энэ нь англи хэлний мэдлэгийг минь тэлж байгааг анзаарсан. Мөн хичээл бэлдэх явцдаа судрыг илүү үр дүнтэй судлах аргыг олж, сударт Бурханы гайхалтай нууцууд байдгийг олж мэдсэн. Мөн би хүүхдүүддээ заасан зарчмаа өөрөө хэрэгжүүлэхгүй бол болохгүй гэж үздэг бөгөөд энэ нь зарлигуудыг илүү өндөр түвшинд дагах боломж олгож байгааг хараад, тэдэндээ талархахын сацуу улам бүр хайрлаж, өөрийн бүхий л хүчээр туслахыг хүсэх болсон. Бурхан биднийг өсгөн хөгжүүлж, адислахын тулд Сүмийн дуудлагат ажил өдгийг гэрчилж байна. Есүс Христийн нэрээр, Амен ■

Семинарын суралцагч Мөнхсаруулын гэрчлэл

Би гурван жилийн өмнөөс Сүмийг сонирхож эхэлсэн боловч тууштай явдаггүй байлаа. Гэтэл энэ намар ангийн маань хүүхэд намайг гомдоосон учраас би уйлсаар гэртээ ирсэн юм. Тэр үед ээж надад сүмдээ явахыг

зөвлөсөн. Би ээжийн юу бодож байгааг мэдээгүй ч зөвлөгөөг нь дагасан юм. Удалгүй өглөөний семинарт явж эхэлсэн бөгөөд семинарт заадаг хичээлүүд надад маш хэрэгтэй зөвлөмжүүдийг өгдөг. Сургаалын


Мөнхсаруул



ГЭГЭЭНТНҮҮДИЙН АМЖИЛТЫН ТҮҮХ

зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлснээр би бусадтай сайхан харилцаж, бусдыг ойлгож сурсан. Муудалцаж байсан ангийн хүүхэдтэйгээ эвлэрч, одоо сайн найзууд болсон. Бурханы сургаалыг сонсож дагаснаар зан байдал минь өөрчлөгдөж, би сурлагаараа ч харилцаа хандлагаараа ч ангидаа манлайлагч сурагч болсон. ■

Семинарын суралцагч Анужингийн гэрчлэл



Анужин

Семинар надад муу зуршил, алдаа дутагдлаа засах боломж олгосон. Урьд нь би өглөө 7:00 цагт арай гэж босон хичээлдээ явдаг байсан бол одоо нойроо ялан дийлдэг болсон бөгөөд өглөө бүр 5:00 цагт аз жаргалтайгаар босон семинартаа явдаг болсон. Мөн урьд нь судар унших нь ямар ч сонирхолгүй санагдаж, залхуу хүрдэг байсан бол одоо судраасаа шимтэн суралцаж, олон зүйлийг сурч байна. ■

Б.Амартүвшин БЯИС-ийн найрал дууны аялан тоглолтод оролцоно

Хавай дахь Бригам Янгийн их сургуулийн найрал дууны хамтлаг энэ зун Япон Улсад 14 хоногийн хугацаатай аялан тоглолт хийнэ. Энэхүү аялан тоглолтыг хийх хамтлагийн бүрэлдэхүүнд Б.Амартүвшин ах оржээ. Тэрээр урьд нь Гадасны найрал дуунд гурван жил дуулсан бөгөөд энэ үеэс эхлэн найрал дуунд дуртай болж улмаар дуулах ур чадвартай болжээ. Б.Амартүвшин 2015 оны нэгдүгээр сард БЯИС-д суралцахаар явсан ба 2011-2013 онд Монгол Улаанбаатар номлолд үйлчилсэн байна. Тэрээр уг аялан тоглолтод оролцохын тулд багагүй золиос гаргасан аж. Ажлын хуваарь нь найрал дууны бэлтгэлийн цагтай давхацдаг байсан учир ажлаа сольжээ. Мөн аялан тоглолтын багт орох гишүүдийг сонгон шалгаруулах үед ихэвчлэн хөгжмийн чиглэлээр



Б.Амартүвшин

сурдаг оюутнууд болон бага наснаасаа хөгжмийн боловсрол эзэмшсэн чадварлаг хүмүүстэй өрсөлдсөн ажээ. Б.Амартүвшин анх өөрийгөө голж байсан ч шалгаруулалтад оролцон тэнцсэн байна. Тэрээр энэхүү туршлагаасаа хүн өөрийгөө голыхын оронд оролдоод үзвэл боломж нээгддэг гэдгийг сурчээ. ■

Их Эзэнд өргөсөн амьдрал

Ахмад номлогч Мэйнс ах эгч хоёрыг танилцуулж байна.

Мэйнс ах эгч хоёр долоон хүүхэд, зургаан ач зээтэй өнөр өтгөн гэр бүл юм. Тэд 2015 оны арванхоёрдугаар сард Монгол улсад ирсэн бөгөөд тэдний Монгол дахь номлолын хугацаа 2017 оны тавдугаар сар хүртэл үргэлжлэх юм. Өмнө нь тэд 2010-2013 онд АНУ-ын Колорадо мужид номлолын ерөнхийлөгчөөр үйлчилжээ. Мөн Алан Мэйнс ах 1970-1972 онд Ирланд улсад номлолын ажил хийсэн байна. Тэрээр бизнесийн чиглэлээр суралцаж

төгссөн бөгөөд Сүмийн боловсролын системд 34 жил ажиллажээ. Энэ хугацаанд тэрбээр семинар, институтийн багш, зохицуулагч, бүсийн захирлаар ажиллаж байв. Мэйнс ах ямар нэг зүйл барьж байгуулах дуртай ажээ. Байшин барих, мод тарих, машин засах гэх мэт. Харин Лаури Мэйнс эгч зурагт ном хийх дуртай. Тэд Монголд ирээд, Улаанбаатар, Зүүн хараа, Дархан, Сэлэнгэ, Мөрөн, Ховд зэрэг хотуудад томилолтоор очиж ажиллажээ. Мэйнс ах эгч хоёр



Мэйнс ах эгч хоёр

Монгол оронд хайртай болсон бөгөөд Монголын гэгээнтнүүдийн хүчирхэг итгэл, сургаалыг хайрлах хайр тэднийг гайхшируулсан байна. Тэд олон гишүүний гэрээр зочилж, танилцсан юм. Тэд монгол хоолонд дасаж, Мэйнс ах хуушуурт, Мэйнс эгч цуйванд илүү дуртай болжээ.

БЯИС төгсөгчдийн галын дэргэдэх цугларалт боллоо



Д.Анхбаяр эгч гэрчлэлээ хуваалцаж байна

2016 оны хоёрдугаар сарын 21-ний орой Баянзүрх байранд Хавай дахь Бригам Янгийн их сургууль төгсөгчдийн галын дэргэдэх цугларалт болж өнгөрлөө. Уг цугларалтад 200 гаруй залуус оролцсон бөгөөд БЯИС-ийг саяхан төгсөж ирсэн Ц.Ууганбаяр ах, Д.Анхбаяр эгч нар гэрчлэл, туршлагаасаа хуваалцсан. Мөн тун удахгүй тус сургуульд суралцахаар явах гэж буй Г.Мөнгөнсүх ах гэрчлэлээ хуваалцаж, гадас, дүүргийн хамтарсан найрал дуучид онцгой дуу дуулж, цугларагсад урам зориг өгсөн юм. Гадасны ерөнхийлөгч О.Одгэрэл

Тэд Дезерет олон улсын энэрлийн байгууллагыг хариуцан ажилладаг бөгөөд эмнэлгийн болон, хүлэмжийн төсөл, сайн дурын англи хэлний багш нарын төсөл зэргийг хариуцан ажилладаг. Мөн mongtonnewsroom.mn Сүмийн албан ёсны мэдээллийн сайтад мэдээлэл оруулдаг ажээ. Мэйнс ах эгч хоёрын амьдралын замналаас бид Их эзэнд цаг зав, авьяас чадвар гээд өөрт буй бүхнээ өргөсөн үнэнч шавийн үлгэр жишээг тодхон харж болох юм. ■

ах IWORK хөтөлбөрийн хорооны шалгуурт орсон өөрчлөлтийг танилцуулсан бөгөөд энэ нь БЯИС-д сурах хүсэлтэй залууст өөсдийгөө хэрхэн бэлтгэх ёстойг илүү сайн ойлгоход туслав. Гадасны ерөнхийлөгчийн хоёрдугаар зөвлөх С.Цэрэнням ах ирсэн залуучуудын дунд асуулт хариултын тэмцээн зохиож, зөв хариулсан залууст бэлэг өгсөн ба энэ нь тэдэнд БЯИС-ийн тухай илүү мэдээлэлтэй болоход тусалсан. Төгсгөлд нь БЯИС-д сурч байгаа монгол оюутнуудын тухай видео бичлэг үзсэн бөгөөд ирсэн хүн бүр тийш очиж сурах хүсэлтэй болсон. Дашрамд дурдахад БЯИС-ийн удирдлагууд монгол оюутнуудыг эх орондоо эргэж ирэх амлалтаа сайн биелүүдэг учраас энэ сургууль байгуулагдсан үндсэн зорилгыг хамгийн сайн хэрэгжүүлдэг хүмүүс хэмээн ихэд үнэлдэг билээ. Сүүлийн зургаан төгсөлтийн бүх оюутан эргэж ирсэн нь өөр олон монгол оюутан БЯИС-д сурах үүд хаалгыг нээсэн юм. ■

Дархан хотын шилдэг байгууллагаар манай Сүм шалгарлаа

Дархан-Уул аймгийн Дархан хотын 2015 оны хамгийн шилдэг олон нийтийн байгууллагаар манай Сүм шалгарчээ. Учир нь Дархан хот дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бие даах чадварыг хөгжүүлэх сургалтад 189 хүн хамруулж, 24 хүнийг ажлын байртай болоход тусалсан байна. Мөн Дархан хотын “Цусны төв”-ийн өрөө тасалгаануудыг тохижуулж, тоног төхөөрөмж хандивлажээ. Соёл урлагийн хөгжилд ч мөн хувь нэмэр оруулж, “Уулын оргил дээр” найрал дууны аялан тоглолт зохион байгуулж, уг тоглолтод оролцсон залуус Дархан хотын 2-р хорооны хашаануудыг будаж, гудамжны хогийг цэвэрлэж, эмзэг бүлгийн айл өрхүүдэд тусламжийн бараа хүргүүлсэн тул ийнхүү ажил үйлсээрээ манлайлагч байгууллагаар шалгарсан байна. ■

Шагналыг Дархан дүүргийн ерөнхийлөгч Доржзодов ахад гардуулав



2014 оны 7-р сараас 2016 оны 2-р сард
бүрэн цагийн номлолд дуудагдсан номлогчид

Монгол Улаанбаатар номлолд



О.Болор эгч-
Сансар салбар



Ахлагч Б.Мөнхболд-
Эрдэнэт 2 салбар



Ахлагч Г.Түмэннасан-
Дархан 1 салбар



Ахлагч Э.Билгүүн-
Хан-Уул тойрог



Ахлагч Б.Бат-Орших-
Хан-Уул тойрог



Б.Хандсүрэн эгч-
Баянзүрх салбар



Ахлагч Ч.Билгүүн-
Эрдэнэт 2 салбар



Ахлагч Б.Отгонбилэг-
Энхтайван тойрог



Б.Болох-Эрдэнэ эгч-
Сонгино тойрог



Ахлагч Э.Буянбадрах-
Энхтайван тойрог




Н.Солонго эгч-
Американ дэнж салбаар




Г.Баярцэцэг эгч-
Баянзүрх салбар



Н.Ариунтунгалаг эгч-
Өнөр тойрог



Ахлагч А.Төгөлдөр-
Сансар салбар



Ахлагч Д.Хасбаатар-
Жаргалант салбар



Г.Ганцэцэг эгч-
Хан-Уул тойрог




П.Мөнгэрэл эгч-
Оросын Новосибирск



Ахлагч П.Санчир-
Дархан 1 салбар



Г.Номингэрэл эгч-
Энхтайван тойрог




Ахлагч Э.Билгүүн-
Өнөр тойрог



Ахлагч Г.Ганбямба-
Чойбалсан салбар



П.Бадамгэрэл эгч-
Налайх салбар



Г.Батцэцэг эгч-
Жаргалант салбар



Г.Ганбямба эгч-
Эрдэнэт 1 салбар



Ахлагч Д.Мөнгөбат-
Зүүнхараа салбар

Хилийн чанадад дуудагдсан НОМЛОГЧИД

Солт Лэйкийн Ариун сүмийн талбайн номлолд:



Ж.Мөнхтайван эгч-
Сэлбэ тойрог



Б.Анужин эгч-
Энхтайван тойрог



Н.Үүрцайх эгч-
Американ дэнж салбар

Австрали
Сидней номлолд:




М.Жаргалсүрэн эгч-
Сансар салбар




М.Даваасүрэн эгч-
Энхтайван тойрог



Ахлагч Э.Цолмон –
Сэлбэ тойрог



Э.Алтаншагай эгч-
Хан-Уул тойрог



С.Асрал эгч-
Өнөр тойрог


АНУ Сэйнт
Жорж номлолд:

Канад
Банкүвэр номлолд:

Англи Лондон номлолд:

Аризона Гилберт номлолд:


Юта Орем номлолд:



Б.Лхамсүрэн эгч-
Өнөр тойрог




Б.Өлзийсүрэн эгч-
Сэлбэ тойрог



Ө.Ганцэцэг эгч-
Американ дэнж салбар



Ч.Маралмаа эгч-
Энхтайван тойрог



Ахлагч Г.Оюунболд-
Сансар салбар

Юта Логан номлолд:

АНУ Колорадо
номлолд:

Айдоха, Твинфолс
номлолд:

Калифорни
Санфранциско номлолд:

Австрали
Брисбэн номлолд:




Э.Цэцгээ эгч-
Жаргалант салбар




Э.Отгонбилэг эгч-
Сансар салбар



Г.Намуун эгч-
Жаргалант салбар



А.Ариунзаяа эгч-
Налайх салбар



Ахлагч Н.Батхуяг-
Жаргалант салбар